

МОНГОЛЫН ОРОН НУТГИЙН МЭДЭЭ

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

Бошиглогчийг Дага

Азийн Бүсийн Ерөнхийлөгч Далын Ахлагч Кент Д.Ватсон

Тэр 85 настай ч гэсэн энэхүү будилж төөрөлдсөн дэлхийд, тэр замыг мэддэг. . .

Хэдэн жилийн өмнө манай Хүүхдийн Хэсгийн ариун ёслолынц цуглаан “Бошиглогчийг дага” гэсэн уриан дор болж билээ. Хүүхэд бүр том хөөсөнцөрөөр хийсэн дүрсийг барьж, жагсаалаар алхаж цуглааны байрны өмнө ирээд, “Бошиглогчийг дага” дууллыг дуулж эхэлсэн. Дууны бадаг бүрийг дуулах бүртээ хүүхдүүд хөөсөнцөрөөр хайчилсан сүүдэр зурган дүрсээ эргүүлэхэд бошиглогчийн өнгөт зураг болон солигдож байлаа.

Эхний бадаг нь “Бидний мэдэх анхны бошиглогч Адам байсан” гэж эхэллээ.

Тэд бүгдээрээ даган дуулах үед дуу улам чангаран, бүр гурван настай хүүхэд ч: “Бошиглогчийг дага. . . бошиглогчийг дага. . . битгий замаа алд. . . тэр замыг мэддэг” гэж чангаар дуулж байв. Хоёр дахь бадаг: “Енох бошиглогч байсан, тэр сайн бүхнийг заасан” гэсэн үгсийг хэлэн дуулахад найрал дуу улам чанга болж байлаа. Дараа нь “Ноа. . . үгийг номлохоор дуудагдсан,” “Абрахам. . . хүүтэй болохын төлөө залбирсан”. Хүүхдүүд инээмсэглэн нэг нэгээрээ барьж байсан хайчилбараа эргүүлж байв. Найрал дуучид Адам, Енох, Ноа, Абрахам, Мосе, Самуел, Иона, Даниел. . . бүгдийг тааламжтайгаар олон дахин давтан дуулсан болохоор бидний чихэнд хонногшин үлдсэн юм. Би бодохдоо эдгээр бошиглогчид бүгд эртний бошиглогчид, яагаад тэдэнд орчин цагийн бошиглогчдын талаар бадаг байдаггүй юм бол? хэмээн гайхширч билээ.

Тэднийг сүүлийн бадгаа дуулах үед би илүү сайн ойлгосон. . .

“Хүмүүс нь будилж самуурсан дэлхийд бид байна.

Хэрэв та нар итгэхгүй байгаа бол мэдээ үз.

Хэрэв бошиглогчдод анхаарлаа хандуулж, хэлснийг нь дагавал

Бид туулах замынхаа туршид чиглэлийг авч чадна.”



Азийн Бүсийн Ерөнхийлөгч, Далын Ахлагч Кент Д.Ватсон

Бошиглогчдын сургаал мөнхийн юм гэдгийг хүүхдүүд надаас илүү мэдэж байсан. Хэрэв бид тэднийг дагах юм бол замаа алдаж төөрөхгүй. Бидэнд замаа алдаж төөрөхгүй байхад маань тусалж байсан мөн тусалсаар ч байгаа 85 настай гурван (үнэндээ дөрвөн) бошиглогчийг бид сайн мэднэ.

Лорензо Снөү (85 насандаа)

Энэ жил, манай Нийгмийн Халамж болон Санваарын чуулгын цуглаануудад бид Ерөнхийлөгч Лорензо Снөүгийн амьдралын талаар судалж сурах юм. Тэрээр 85 нас хүрэхийнхээ өмнөхөн бошиглогчоор дуудагдсан. Тэр зөвхөн гурван жил үйлчилсэн ч 17 настайдаа Сүмийн гишүүн болсон цагаас хойш түүний бүхий л амьдрал Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд бие даасан өөртөө итгэлтэй байхад нь туслах Их

Эзэний зэмсэг байхаар түүнийг бэлтгэсэн. Сүм өр зээлэнд орсон хэцүүхэн үед Ерөнхийлөгч Снөү гишүүдэд аравны нэгийн хуулийг илүү сайн ягштал дагахыг заах алсын хараа мөн зоригтой байсан юм. Дараагийн үеийн Хожмын Үеийн Гэгээнтнүүд аравны нэгээ бүрэн төлөх нь бие даасан байдалд суралцах хамгийн баттай арга зам гэдгийг суралцсан. Бид итгэлээ хөгжүүлэх тусам Их Эзэн Өөрийн амласан адислалуудыг биелүүлэх боломжтой байдаг.

85 насандаа 1899 оны 4-р сарын 6-нд Ерөнхий Чуулган дээр Ерөнхийлөгч Лорензо Снөү: “Бага зэрэг гунигтай байх үедээ эргэн тойрноо харж, өөрөөсөө илүү хүнд бэрх байдалд буй хэн нэгнийг олж, түүн дээр очоод түүний зовлон шаналал нь юу болохыг олж мэд. Тэгээд Их Эзэний чамд өгсөн тэрхүү мэргэн ухааны тусламжтайгаар түүний зовлонг нимгэлэхийг хичээ. Хамгийн түрүүнд чи уйтгар гуниг тань үгүй болсныг мэдэрч, сэтгэл тань хөнгөрч, Их Эзэний Сүнс чам дээр бууж бүх зүйл гэгээрэн сэнхэрсэн мэт санагдах болно” хэмээн заасан.

Түүний захиас өнөөдрийн амьд бошиглогчийн “Тэднийг Авар” гэснийг санагдуулж байгаа өөр нэгэн зүйл юм. Энэ жил би Лорензо Снөү болон түүний заасан зүйлүүдийн талаар илүү ихийг суралцахыг эрэлхийлж байна.

Спенсер В. Кимбалл (85 насандаа)

80 настай мөн эрүүл мэнд нь тийм ч сайнгүй байх үедээ Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл: “Бид алхаагаа түргэгсэх хэрэгтэй бөгөөд үүнийг бид одооноос хийх хэрэгтэй” гэж бидэнд заасан.

Ерөнхийлөгч Кимбалл 85 настай байхдаа Ням гарагийн цуглааны шинэ нэгтгэсэн хуваарийг бий болгосон юм. Үүнээс өмнө туслах бүлгүүдийн цуглаан долоо хоногийн дундуур, Ням гарагийн цуглаан өдөрт хоёр удаа өөр цагуудад болдог байв. Гурван цагийн нэгтгэсэн хуваарьт орсон энэ сүнслэг өөрчлөлт үргэлжийн завгүй дэлхийд гэр бүлийнхэнтэйгээ илүү их цагийг өнгөрөөх боломжийг гишүүдэд өгсөн билээ.

Ерөнхийлөгч Кимбаллын 85 насны ойн баярын үйл ажиллагаан дээр түүний зөвлөх Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон бидэнд “Бошиглогчийг дагах арван дөрвөн үндсэн зарчим”-ыг заасан. Эдгээр нь:

1. Бошиглогч нь бүх зүйлст Их Эзэний өмнөөс ярьдаг цорын ганц хүн.
2. Амьд бошиглогч нь судруудаас ч илүү чухал.
3. Амьд бошиглогч нь нас барсан бошиглогчоос илүү чухал.
4. Бошиглогч сүмийг хэзээ ч төөрөлдүүлэхгүй.
5. Бошиглогч аливаа сэдвээр ярьж эсвэл аль нэгэн цагт аливаа асуудалд үйлдэхийн тулд ямар нэгэн урьдчилсан тодорхой сургалт эсвэл итгэмжлэл шаардлагагүй.
6. Бошиглогч бидэнд судар өгөхийн тул ‘Их Эзэн ийн айлдаж байна’ гэж хэлэх шаардлагагүй.
7. Бошиглогч байнга бидний мэдэхийг хүсч байгаа зүйлсийг биш харин мэдэх хэрэгтэй зүйлсийг хэлдэг.
8. Бошиглогч нь хүмүүний эргэцүүлээр хязгаарлагддаггүй.
9. Бошиглогч цаг зуурын эсвэл сүнслэг аливаа асуудлаар илчлэлт хүлээн авч чадна.
10. Бошиглогч иргэний асуудлаар зөвлөж болно.
11. Ихийг судалж мэдсэн эсвэл баян чинээлгээсээ бардам болсон энэ хоёр бүлэг хүмүүс бошиглогчийг дагахад маш хэцүү.
12. Бошиглогч дэлхийд эсвэл дэлхийн зүйлст нэр алдартай байх шаардлагагүй.
13. Бошиглогч болон түүний зөвлөхүүд Сүмийн хамгийн өндөр чуулга болох Тэргүүн Зөвлөлийг бүрдүүлдэг.

14. Бошиглогч ба ерөнхийлөгчийн зөвлөл, амьд бошиглогч ба Тэргүүн Зөвлөл, тэднийг дагалвал адислагдана, тэднээс татгалзвал зовж зүдрэх болно.

Томас С.Монсон (85 насандаа)

Өнөөгийн амьд бошиглогч Ерөнхийлөгч Томас С.Монсон саяхан 85 насныхаа ойг тэмдэглэсэн билээ. Ерөнхийлөгч Монсонгийн ажлын өрөөний ханан дээр Аврагчийн зураг байдаг. Бошиглогч маань: “Хэцүү байдалтай тулгарах үедээ би үргэлж энэхүү зураг руу хараад өөрөөсөө ‘Тэр юу хийх байсан бол?’ гэж асуудаг. Дараа нь би түүнчлэн хариулахыг хичээдэг” хэмээн хэлсэн. “Би үргэлж ‘Их Эзэний захиа даалгаварт’ байх болтугай” гэх нь Ерөнхийлөгч Монсонгийн өөртөө итгэх найдвар нь юм.

Түүний саяхны мэдэгдэлд “бүх зохистой бөгөөд боломжтой залуу эрэгтэйчүүд 19 нас биш харин 18 насандаа номлолын үйлчлэлд гарч болно” мөн “үйлчлэх хүсэлтэй зохистой залуу эмэгтэйчүүд 21 нас биш 19 насандаа номлолын үйлчлэлд гарч болно” хэмээн тунхагласныг бүх Хожмын Үеийн Гэгээнтнүүд сэтгэл бахдан хүлээн авсан юм.

Адам бошиглогч байсан, Абрахам бошиглогч байсан. . . бошиглогчийг дага, бүү төөрөлд. Мосе, Ноа. . . бошиглогчийг дага, тэр замыг удирдан чиглүүлэх болно. Сайн мэдээний сэргээлтээс хойш энэ бүрэн дүүрэн цаг үед Иосеф Смитээс эхлэн, хэдийгээр ихэнх нь 85-аас дээш настай байсан ч бидэнд заасан, биднийг агуу ил тодорхой мөн алсын хараатайгаар удирдан залсан 16 бошиглогчдоор бид адислагдсан билээ. Бошиглогчийг дага, бүү төөрөлд.

Өнөөдөр мөн бид 85 настай амьд бошиглогчоор адислагдсан байна. Би Ерөнхийлөгч Томас С.Монсонд хайртай. Би түүнийг Их Эзэний бошиглогчийн хувьд хүндэлдэг мөн дэмждэг. “Учир нь түүний үгийг та нар миний амнаас гарсан мэтээр бүхий л тэвчээр хийгээд итгэлд хүлээн авах ёстой.”

Би түүний тухай бодоход, хөөсөнцрөөр хайчилсан бошиглогчдын дүрсийг барьж байсан Хүүхдийн Хэсгийн хүүхдүүдийг санаж, бошиглогчийгоо урьд урьдынхаасаа илүүтэй дагах хүслийг надад төрүүлдэг. Тэр үнэхээр Адам, Инох, Ноа, Абрахам, Мосе, Самуел, Иона мөн Даниелтэй адил юм. Бошиглогчийг дага бүү төөрөлд. Бошиглогчийг дага, тэр замыг удирдан хөтлөх болно. ■

Орон Нутагт Болж Буй Үйл Явдлууд

2013 он Монголын Гэгээнтнүүдийн хувьд онцгой жил бөгөөд энэ онд бид Есүс Христийн Сэргээгдсэн сайн мэдээ Монгол оронд түгэн дэлгэрсэний 20 жилийн ойгоо тэмдэглэж, жилийн турш олон сүнслэг үйл ажиллагаа зохион байгуулалттайгаар үргэлжлэн явагдах билээ. Өнгөрсөн хорин жилийн турш олон гайхамшигтай Бурханы сонгогдсон бүрэн цагийн номлогчид мөн хүмүүнлэгийн төрөл бүрийн төсөл хэрэгжүүлэхээр олон ахмад номлогчид Монгол оронд номлолын үйлчлэлээ хийж, Бурханы охид хөвгүүд, тийм ээ, Израилын овгийн нэгэн ахан дүүс гэдгээ сүнслэгээр мэдрэн, Христийн хайраар бие биенээ тэтгэн урамшуулсаар ирсэн. Өнөөдөр Монгол Улсын Сүмийн гишүүнчлэлийн тоо арван мянга гаруйд хүрч, нэг гадас, зургаан тойрог мөн хоёр дүүрэг, 17 салбарт сайн мэдээнд хамтдаа суралцаж байна. Бид бүхний зорилго нэгэн өдөр Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд хамтдаа мөнхөд баясан жаргах бөгөөд энэ зорилгоо гүйцэлдүүлэхийн төлөө эцсээ хүртэл тэвчээртэйгээр, дуулгавартайгаар Эзэний зарлигуудын дагуу амьдрахыг хичээн, Түүний хүүхдүүдэд үйлчлэлийг өргөн зүтгэсээр байна. Бурханы өмнө бодгаль бүр үнэтэй тул энэ онд бүгдээрээ

идэвх султай ах эгч нарыгаа АВРАЛД эргүүлэн авчирцагаая! Бидний гэрчлэл мөн үйлчлэл бүхэн тэнгэр элчийн хуудсанд тэмдэглэгдэн үлдсээр байх болно.

2013 оныг ахан дүүсээ АВРАЛД буцаан авчирх жил болгоцгооё! Үе үеийн Номлолын Ерөнхийлөгч нар Монголд айлчлан ирэхээр төлөвлөж байгаа тул хуучин андуудтайгаа уулзах торгон мөчийг бүү алдаарай.

Өнөөгийн амьд бошиглогч Томас С.Монсон илчлэлтээр Бурханы дуудлагыг хүлээн авч, Христийн сайн мэдээг номлох ажилд орчин цагийн залуусыг эрэгтэйчүүд 18, эмэгтэйчүүд 19 наснаас үйлчлэх боломжийг нээлээ. Энэ бол бас нэгэн хүчтэй гэрчлэлийн илрэл бөгөөд манай залуус хэдэн зуугаараа Түүний ажилд урамтайгаар орж, “Миний сайн мэдээг номло” хэмээх Түүний дуудлага бүрэн ёсоороо биеллээ олох цагийг ойртуулах болно гэдэгт бид итгэлтэй байна. Монголын Гэгээнтнүүд ээ, залуус болоод тэдний аав ээж, гэр бүлийнхэн минь, АВРАЛД Түүний хүүхдүүдийг авчирх ажилдаа эв нэгдэлтэй, хүчирхэг байцгаая.

“Христийн Цагаатгалаар дамжин Сайн мэдээний хуулиуд хийгээд ёслолуудад дуулгавартай байснаар бүх хүн төрөлхтөн аврагдана гэдэгт бид итгэдэг” ИТ 1:3. ■

Монгол дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Түүхээс

Улаанбаатар Баруун Гадасны түүхч А.Тунгалаг

1995 он. Улаанбаатар, Сэлбэ салбар өргөжиж, Улаанбаатар номлол зохион байгуулагдав.

- 1995.02 сар. Улсын Их Хурлын гишүүн Раднаа-сүмбэрэлийн Гончигдорж АНУ-ын Солт Лейк мужийн Бригам Янгийн Их Сургуульд айлчлан очсон байна.
- 1995.02.08. Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гишүүн Ахлагч Жон Х.Гроберг Монголд айлчлан ирж, бүрэн цагийн 20 номлогч болон номлолд үйлчлэх боломжтой эгч нартай ярилцлага хийсэн байна.
- 1995.02.26. Сэлбэ салбарын ариун ёслолын цуглааны гишүүдийн ирц 299 хүрчээ.
- 1995.03 сар. Эрдэнэт салбар зохион байгуулагдав.
- 1995.04 сар. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли, Ахлагч Ричард Е.Кукийг Монголын Улаанбаатар Номлолын Ерөнхийлөгчөөр дууджээ. Ахлагч Ричард Е.Кук, Систер Мэри Н.Кук нар Прово дахь Номлолын Ерөнхийлөгчийн сургалтыг дүүргэсэн байна.
- 1995.04.11. Монголын анхны номлогч нар Систер Уртнасангийн Соёлмаа Провогийн Номлолд, Систер Магсарын Батчимэг Солт Лейкийн Ариун Сүмд үйлчлэх дуудлага авчээ.
- 1995.04.11. Эрдэнэт салбарын анхны баптисмаар 3 эрэгтэй, 5 эмэгтэй шинээр хөрвөгджээ.
- 1995.04.25. Эрдэнэт салбар нээгдэв.
- 1995.04.26. Туул салбар нээгдэхэд бэлтгэгдэв.
- 1995.07.01. Ахлагч Ричард Е.Кук ба Систер Мэри Н.Кук нар Монголын Улаанбаатар Номлолыг нээх үйлчлэлд хүрэлцэн ирж, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Улаанбаатар Номлолыг албан ёсоор байгуулснаар анхны номлолын

Ерөнхийлөгчөөр Ахлагч Ричард Е.Кук үйлчилсэн билээ.

1995.08.14. Эрдэнэт салбарын 15 гишүүн 30 болон өсч, бүрэн цагийн дөрвөн номлогч мөн ахмад хос номлогч Ахлагч ба Систер Оллсоп нар үйлчлэх болжээ.

1995.09 сар. Сүмийн Боловсролын Систем ажиллаж эхлэв. Т.Энхтүвшин ах, Т.Бат-Өлзий ах нар анхны Монгол салбарын ерөнхийлөгчдөөр дуудагдлаа.

1995.12.19. Энхтайван салбар нээгдэхэд бэлтгэгдэв.

1995.12.28. Систер Бямбажавын Долгорсүрэн Калифорнийн Френсо Номлолд дуудагдав.

1996 он. Улаанбаатар номлолын удирдлага дор Улаанбаатар дүүрэг зохион байгуулагдав.

1996.01.19. Пристүүдийн анхны уулзалт болов.

1996.01.29. Энхтайван салбар зохион байгуулагдав.

1996.02 сар. Номлолын Ерөнхийлөгч Кук ахын санал тавьснаар Т.Энхтүвшин ах Монгол Улсын Их Сургуулийн багшийн ажлаа орхиж, Сүмийн хагас цагийн ажилтан болж, түүний туслахаар Д.Мөнхцэцэг эгч ажиллаж байв.

1996.02.27. Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гишүүн Жон Х.Гроберг Монгол Улсын Засгийн газартай албан ёсны уулзалт хийж, номлогчид болон хүмүүнлэгийн ажилтан нарыг Монгол Улсад нэвтрэх визийн зөвшөөрөл авсан байна.

1996.02.27. Улаанбаатар Номлолын Ерөнхийлөгч Ричард Е.Кук Дарханд ариун ёслол явуулах зөвшөөрөл өгсөн байна.

1996.03 сар. Дарханд анхны номлогчид Сэргээгдсэн сайн мэдээг түгээж, тус салбарыг Ахлагч Тимот, Ахлагч Томсон нар нээн, үйлчилжээ.

1996.03.22. Анхны бүрэн цагийн номлогч дөрвөн систер Натали Ромрелл, Катерина Сего, Шерил Мотт болон Марсие Веллман нар иржээ.

1996.04.10. Д.Мөнхцэцэг эгч номлолд үйлчлэхийг хүссэн Номлогчийн өргөдлөө Номлолын Ерөнхийлөгчид хүлээлгэн өгсний маргааш Сүмийн орчуулгын газрын төлөөлөгчөөс Мормоны номыг Монгол хэлэнд орчуулах ажилд туслахыг хүссэн урилга хүлээн авсан байна.

1996.06.27. Улаанбаатар Номлолын

Ерөнхийлөгчөөр Гари Е.Кокс, Систер Жоис Кокс нар дуудагджээ. Тэд Монгол дахь номлолоо 1996 оны 7 сарын 1-нээс эхлүүлээ.

1996.09 сар. Институт Семинарын ангиуд хичээллэж эхэлсэн байна.

1996.09.15. Монголын Улаанбаатар Номлолын удирдлага дор Улаанбаатар Дүүрэг шинээр зохион байгуулагдаж, ерөнхийлөгчөөр Тогтохын Энхтүвшин ах дуудагджээ.

1996.10.01. Сүмийн гишүүдийн тоо өссөөр мөн шинэ сорилтууд ирэх болсон энэ үед Сүмийн байртай болох чухал асуудал тулгарчээ. Шинэ байрыг “Төв Байр” хэмээн нэрлэж дотоод танхимд их засвар оруулж, шинэчлэн засварлах ажилд Бөөрчи ах ажиллаж тохижуулсныг олон гишүүд дурсан санаж байдаг билээ.

1996.10.24. Энэ өдөр Хонг Конгийн Ариун Сүмд лацдан холбуулж ариун сүмийн адислал хүртсэн Монголын анхны гэр бүл нь Тогтохын Энхтүвшингийн гэр бүл байлаа.

1996 оны турш олон төсөл хүмүүнлэгийн тусламжаар хийгджээ.

1997 он. Улаанбаатар номлол, Улаанбаатар дүүрэг

1997.01.01. Бүрэн цагийн 45 номлогч Монголын Улаанбаатар номлолын үйлчлэлд гарчээ.

1997.01 сар. Ахлагч нар Налайхын Городокт сайн мэдээ зааж эхэлжээ.

1997.02 сар. Д.Мөнхцэцэг эгч 1996 оны 9-р сард Ариун Сүмийн талбайн номлолд үйлчлэхээр дуудагдаж, Прово дахь Номлогчдын бэлтгэх төвд суралцаад, номлолдоо үйлчлэхийн хамт Мормоны Номын орчуулгын ажлыг эхэлжээ. Шаргуу хөдөлмөрлөсний үр дүнд 1, 2 Нифайн орчуулгыг дуусгаж, орчуулгыг М.Батчимэг шалгаж, агуулгыг нь У.Соёлмаа хянаж байжээ.

1997.04.26. Налайхын салбар шинээр гурван хөрвөгчөөр нэмэгдэв.

1997.04 сар. Улаанбаатар Дүүргийн чуулган чуулж, Дүүргийн Нийгмийн Халамж, Залуу Эмэгтэйчүүдийн зөвлөл шинээр зохион байгуулагдав.

1997.06.05. Ховд салбар нээгдэв. Нэг гэр бүлийн 4 хүн шинээр хөрвөгджээ.

1997.06.12. Арванхоёр Төлөөлөгчийн гишүүн Ахлагч Жозеф Б.Виртлин Монголд айлчлан ирж, Парламентын гишүүн Р.Гончигдоржтой уулзах үеэр Монгол Улсад Сүмээс

Хүмүүнлэгийн Тусламж үзүүлж байгаад тэр талархлаа илэрхийлсэн байна.
1997.07 сар. Ахлагч нар Багануурт сайн мэдээ зааж эхэлсэн байна.
1997.09 сар. Институт Семинарын хөтөлбөр анх удаа зохион байгуулагджээ.
1997.10.18. Багануур салбар нээгдэв.
1997.11.10. Эрдэнэт салбарт оросуудад зориулсан анхны ариун ёслолын цуглаан болов.
1997.11.20. Дархан, Городок, Сонгино болон Баянзүрх салбарууд зохион байгуулагдав.
1997 оны турш Дохионы хэлээр хичээл заагдаж, анхны хөрвөгч Эрдэнэ-Сувд Дархан салбарт баптисм хүртэж, Сүмийн гишүүн болжээ.

1998 он. Улаанбаатар номлол, Улаанбаатар дүүрэг

1998.02 сар. Ахлагч нар Сэлэнгийн Сүхбаатар мөн Сайншанд, эртний хот Хархоринд сайн мэдээ зааж эхэлжээ.
1998.03 сар. Улаанбаатар Дүүргийн гурван салбар зургаан салбар болон өргөжив.
1998.05 сар. Ахлагч нар Ховдоод дахин сайн мэдээ зааж эхэлжээ.
1998.09 сар. Сүмийн Үйлчлэлийн төв нээгдэж, захирлаар Ахмад номлогчид, Ахлагч мөн Систэр Миллер үйлчилж байжээ.
1998.06 сар. Ховд салбар зохион байгуулагдав.
1998.08.18. Улаанбаатар болон Оросын Номлолд үйлчилж буй хорин эгч, ирэх сард номлолд үйлчлэх хоёр эгч нар Хонг-Конгийн Ариун Сүмд орж, хувийн хишгээ авсан байна. Энэ ажилд Д.Мөнхцэцэг эгч орчуулагч, хөтчөөр үйлчилжээ.
1998.12.31. Монгол Улаанбаатар Дүүргийн Ерөнхийлөгчийн нэг ба хоёрдугаар зөвлөхөөр Гансүх болон Ганболд нар дуудагдав.
1998.12.31. Бүрэн цагийн 80 номлогч Улаанбаатар Номлолд үйлчлэхээр гарчээ.
1998 оны турш Орчуулгын Зөвлөл Мормоны Номны орчуулга дээр ажилласан байна.

1999 он. Улаанбаатар номлол, Улаанбаатар дүүрэг

1999. 03 сар. Чойбалсан салбар нээгдэв.
1999.05 сар. Сүмийн үйл ажиллагаанд зориулсан шинэ байр баригдах болов.
1999.06 сар. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн анхны байр болох

барилгачдын талбай дээрх Төв байр маань нээгдэж, ёслолыг Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн Ахлагч Ричард Е.Кук удирдан нээв.

1999.07.01. Улаанбаатар Номлолын Ерөнхийлөгч Гари Е.Кокс, Систер Жоис Кокс нарын үйлчлэл өндөрлөж, шинэ Ерөнхийлөгчөөр Глен Харлан Кларк, Систер Мэри Алисо Кларк дуудагдав.
1999.07 сар. Мормоны Номын орчуулгын ажил дуусч, хянах ажилд Монгол хэл, уран зохиолын багш, мэргэжилтэн нар оролцон ажилласан ба үргэлжлэн батлуулах, хэвлэх ажиллагаа явагджээ.
1999.09 сар. Улаанбаатар дүүрэг нь Улаанбаатар хойд дүүрэг хэмээн өргөжин хоёр дүүрэгт хуваагдаж, шинэ салбарууд зохион байгуулагдав.
1999.09.01. Институт, Семинарын сургалт албан ёсоор эхэллээ.

2000 он. Улаанбаатар дүүрэг, Улаанбаатар хойд дүүрэг

2000.01.07. Сүмийн шинэ Чингэлтэй байр онцгойлон адислахаар Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гишүүн Ахлагч Уаллас Ф.Брайнер, Ахлагч Вон нар ирсэн байна. Ерөнхийлөгч Цэрэнням /Чингэлтэй салбар/, Батжаргал /Сүхбаатар салбар/, Лхагвадорж /Хайлааст салбар/ нар Сүмийн үйл ажиллагаа явуулах шинэ байртай болсонд талархан, гэрчлэл хуваалцав.
2000.01.30. Улаанбаатар Дүүргийн Гэр бүлийн түүхийн галын дэргэдэх ярилцлага анх удаа зохиогдож, 200 гаруй гишүүд оролцжээ.
2000.02.12. Улаанбаатар дүүргийн бага хурал хоёр өдөр хуралдаж, 500 гаруй гишүүд оролцжээ.
2000.02.15-29. Улаанбаатар дүүргийн салбаруудад анх удаа аудитын шалгалт хийгджээ.
2000.04.16-18. ХҮГС-ийн Нийгмийн Халамжийн ерөнхий зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Жэксэн эгч Солт Лейк хотоос ирж, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот дахь гишүүдтэй уулзаж, галын дэргэдэх ярилцлага зохион байгуулав.
2000.05.13-17. Бригам Янгийн Их Сургуулийн Бүжгийн хамтлаг айлчлан тоглолт хийв.
2000.07.09. Азийн Бүсийн Ерөнхийлөгч Крее-А Коффорд, нэгдүгээр зөвлөх Ричард Е.Кук нар Монголын дүүргийн бүх шатны удирдагчдад сургалт явуулжээ.

2000.07 сар. Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн 1-р зөвлөх Ахлагч Ричард Е.Кук ах, Солт Лейк хотоос Ахлагч Вертлин ах нар Улаанбаатар хотод ирж, ирээдүйн Гадасны төвийн барилгын асуудлаар хоёр хоног ажиллацгаажээ.

2000.08.02. Монгол Улаанбаатар Номлол вэб хуудастай болжээ.

2000.08 сар. Монголын Улаанбаатар дүүрэг болон Улаанбаатар хойд дүүргийн чуулган чуулаа. Сүхбаатар, Хан-Уул, Сансар, Өнөр, Налайх, Хуучин Дархан салбарууд шинээр зохион байгуулагдаж, шинэ байгуулагдсан хойд дүүргийн ерөнхийлөгчөөр Даваасамбуугийн Ганболд, 1-р зөвлөх Цэндийн Энхбаатар, 2-р зөвлөх Дүнхчигийн Ганбаатар нар, Улаанбаатар Дүүргийн ерөнхийлөгчөөр Цэрэндоржийн Батбаяр, 1-р зөвлөх Шарын Хавтгай, 2-р зөвлөх Балжиндондогийн Дашдаваа нар томилогдож, Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гишүүн Ахлагч Ричард Е.Кук тэднийг онцгойлон адислав.

2000.10 сар. Лиакхона сэтгүүл Монгол хэл дээр нийтлэгдэж эхлэв.

2000.10.06-18. Д.Мөнхцэцэг Ариун Сүмийн ёслолуудын бичлэгийг Монгол хэл дээр болгох ажлыг ахлан, санваартны найман удирдагч Ерөнхийлөгч Ц.Батбаяр, түүний зөвлөхүүд Ш.Хавтгай, Б.Дашдаваа нар, ерөнхийлөгч Д.Ганболд түүний зөвлөхүүд Ц.Энхбаатар, Д.Ганбаатар нар, Сүхбаатар салбарын ерөнхийлөгч Галбадрах, Дархан салбарын ерөнхийлөгч Нямсүрэн, Улаанбаатар Дүүргийн анхны ерөнхийлөгч асан Т.Энхтүвшин нарын хамт Солт Лейк хотод 12 хоног ажиллаж, хагас жил тутмын Ерөнхий Чуулганд оролцон, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгч, Үзмэрч, Бошиглогч Гордон Б.Хинклитэй уулзав. Мөн Провогийн Ариун Сүмд орцгоосон байна.

2000.12.22-27. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Улаанбаатар дүүргийн салбарууд Христийн Мэндэлсний Баярын Өдрийг сүнслэг, даруу байдалд ёслол тэмдэглэж Хөгжмийн баяр тоглолт зохион явуулжээ.

2000 онд Сүмийн Баянзүрх байрны газрын зөвшөөрөл, барилгын зураг, төсөл, холбогдох бичиг баримт бүрдүүлэх ажил хийгдсээр байжээ. ■

Улаанбаатар Баруун Гадасны зургаан тойрог чуулганаа хийлээ

Жил тутмын Сүмийн Ерөнхий Чуулганы өмнөхөн Гадасны зургаан тойрог өөр өөрсдийн чуулганаа чуулж, өөрсдийн тойргийн удирдагчдаа дэмжин баталж, хамтдаа сайн мэдээнээс суралцаг билээ. 2012 оны 9,10 сарын Чуулганууд ч мөн ийм л байлаа. Тойрог бүрийн Чуулганд

Улаанбаатар Баруун Гадасны удирдагчид болон дээд прист ах нар оролцож чуулганы уур амьсгалыг илүү сүнслэг болгож байв. Энэ удаад Сэлбэ тойрог шинэ бишоптой болж, Даваасамбуугийн Ганболд ах Сэлбэ тойргийн бишопоор дуудагдан, батлагдав. Бусад тойргийн зөвлөлд өөрчлөлт орсонгүй. ■

Улаанбаатар Баруун Гадас шинэ зөвлөхтэй боллоо

Улаанбаатар Баруун Гадасны 2-р зөвлөхөөр Дамдингийн Энхбат ах дуудагдан батлагдлаа. Тэрээр гэр бүлээрээ сүмийн гишүүн бөгөөд Христийн сайн мэдээнд хөрвөгдөх

зүтгэлдээ амжилт гаргаж яваа манай сүнслэг ах нарын нэгэн билээ. Түүнийг Гадасны гишүүд санал нэгтгэжээр дэмжин батлав. Түүний шинэ дуудлагад амжилт хүсье. ■

Сүмийн алслагдсан нэгжийн туршлагаас

Монгол орны хойморт Оршигч Хөвсгөл нутаг Улаанбаатар хотоос 730 км орчим алсад оршдог бөгөөд Христийн сайн мэдээ анх 2000 онд энэ нутагт түгэн, цөөхөн хэдхэн гишүүнтэйгээр нээгдэж байсан газар өнөөдөр ариун ёслолын дундаж ирцээр зуу гаруй идэвхтэй гишүүнтэй, бүрэн цагийн номлолд 15 залуус үйлчилж, Сүмийн олон

төсөл энд хэрэгжин биеллээ олж, Христийн сайн мэдээгээр амьдарч, ахан дүүсийн сэтгэлээр бие биендээ туслан, олон үйлчлэлийг үзүүлэн хамтдаа нэгдэн халуун гэр бүлийн уур амьсгалаар урагш хөгжин дэвшиж буй Мөрөн салбар юм. Салбарын ерөнхийлөгч Лувсандоржийн Батмөнх ах салбарынхаа гишүүдийн хэрэгцээг сайн мэддэг бөгөөд

“Ургацын баяр”-аа хийж, олон гишүүд ургацын дээжээсээ хуваалцав. Бүгд амттай байлаа.



Ишигтэй ямаанууд маань өсөн үржиж байна.

Дээрэт Олон Улсын Энэрлийн Байгууллагын Үйл Ажиллагаанаас

Нийслэлийн Цагдаагийн газрын Хүүхдийн халамж үйлчилгээний төвийн ногооны талбай

Дээрэт Олон Улсын Энэрлийн байгууллагын 2012 онд хэрэгжүүлсэн Ногооны төсөлд Нийслэлийн цагдаагийн газрын хүүхдийн халамж үйлчилгээний газар хамрагдсан юм. Өөрсдийн гэсэн гэр оронгүй эсвэл гэртээ байх боломжгүй болсон хүүхдүүдийн хувьд тус төвийн аж ахуйн газар нь аюулгүй сайхан газар байлаа. Цагдаа нар тэдгээр хүүхдүүдийн хаягийг тогтоож сургууль, гэрт нь буцаах ажлыг хийдэг. Тэдгээр хүүхдүүд нь “гудамжны хүүхдүүд” гэж дуудагдах нь элбэг. Тус төвийн Улаанбаатар хот дахь байр болон хотоос зайдуу фермд одоогоор нийтдээ 40 орчим хүүхэд хүмүүжиж байна. Фермд ямар ч насны хүүхэд мал маллах болон ногоо тариалах талаар зааж сургадаг. Одоо хичээлийн жил эхэлсэн болохоор зөвхөн гурван хүүхэд тэнд байсан бөгөөд фермийн ажилд тусалж байлаа. Зуны турш хүүхдүүд тэнд байх дуртай.

Тус фермийг ахлан ажиллаж байгаа ойн цагдааг Бямбаа гэдэг. Биднийг очсон өдөр 16 настай хүү Энхтүвшин, 17 настай охин Насаа нар фермийн ажилд тусалж байсан бөгөөд бас нэг хүүхэд малаа хариулж байсан юм. Тэнд ямаа, хонь, тахиа, галуу, цацагт хярууд, адуу гээд маллах амьтад зөндөө байлаа. Харин ногооны талбайд улаан лооль, чинжүү, салатны

байцаа, өргөст хэмх, чацаргана болон маш их төмс тариалсан байсан юм. Тэд ургацаа хурааж өвлийн турш хүүхдүүдийн хүнсэнд хэрэглэдэг байна. Дээрэтээс тэдэнд хүрз, гапуу, тармуур, усны сав, дуслын усалгааны систем, чацарганы бут, төрөл бүрийн ногооны үр их хэмжээгээр хандивласан юм. Хүүхдүүд тэнд ажиллах дуртай бөгөөд ногооныхоо талбайг маш сайн арчилж, зэрлэгийг нь зулгааж хаясан байсан. Тахианууд нь өндөглөж, мөн өндгөө даран дэгдээхий гаргаж тэдний хүнсний хэрэгцээг хангаж байна.

Өнгөрсөн жилүүдэд Дээрэт тус төвд цахилгаанаар ажилладаг том тогоо, хөргөгч болон бусад эд зүйлсийг хэрэгцээнд нь зориулан хандивласан юм. Хүүхдүүдийн байнгын хүнсний хэрэгцээг хангаж байх нь чухал. Өмнө нь хүнсний нөөц нь тус төвд том асуудал болж байсан юм. Түүнчлэн тэд ферм дээрээ хүүхдүүдийг жилийн аль ч үед байлгаж болохын тулд тоосгоор байшин барьж байгаа бөгөөд энэ нь хүүхдүүдийн хувьд мөн туршлага болж байгаа билээ. Өвлийн байр, саравчтай болохоор мал амьтдаа өвөл нь саадгүй маллах боломжтой. Тус ферм Улаанбаатараас зүүн хойд зүгт 10км-ийн зайтай байрладаг бөгөөд хүүхдүүдийг байлгахад аюулгүй, чимээгүй орчинтой. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Хүмүүнлэгийн санд хандив өргөдөг бүх хүмүүстээ баярлалаа. ■